



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Сар шинийн баярыг угтаж хот нийтийн  
аж ахуйн чиглэлээр шуурхай хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Сар шинийн баяраар иргэдийн аюулгүй, ая тухтай шинэлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд дараах чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс дүүргүүдийн Засаг дарга нар болон хот нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхэлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ДААЛГАХ нь:

1. Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын ачилтын давтамжийг 2-3 дахин нэмэгдүүлэх, орон сууц, гэр хорооллын гудамж, үерийн хамгаалалтын далан суваг, тунгаагуур дотор үүссэн ил задгай хогийн цэгүүдийг цэвэрлэж, устгах, нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдал, нуухны шороог цэвэрлэх, авто замын зорчих хэсэг, түүний эгнээ болон ногоон байгууламжийг тусгаарласан төмөр болон тросон хайс, хашлага, нийтийн эзэмшлийн талбайд байршуулсан сандал, хогийн сав, бункер, хөшөө, баримал, авто замын босоо тэмдэг, хог ачиж цуглуулах үйлчилгээнд ажиллаж байгаа хог тээврийн автомашин зэргийг угааж цэвэрлэн, эвдрэл гэмтлийг засварлах, өнгө үзэмжийг сэргээж ажиллахыг "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ, "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ болон Дүүргүүдийн хог хаягдлын үйлчилгээний байгууллага, зам замын байгууламжийн цэвэрлэгээ хариуцсан мэргэжлийн байгууллагуудын удирдлагуудад тус тус;

2. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа үйлчилгээний том болон дунд оврын автобусны гадна болон дотор талын тоос шороо, тортогийг угааж цэвэрлэх, дотор заалны хэсгийн эвдэрч цоорсон сандал, бариул, эд зүйлсийг засаж сэлбэх, өнгө үзэмжийг сэргээх, нийтийн тээврийн үйлчилгээг иргэдийн зорчих хэрэгцээнд нийцүүлэн зохицуулах, нийтийн тээврийн эргэлтийн цагийн хуваарийг мөрдүүлж, байнгын хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Нийтийн тээврийн газарт тус тус;

3. Борооны ус зайлуулах шугам сүлжээний шүүрт болон үзлэгийн худаг, ус хангамж, ариутгах татуургын худаг, мэдээлэл холбооны худаг, дулааны худгийн алдагдсан тагийг нөхөж тагжуулах, эвдэрч гэмтсэн хэсгийг засварлах ажиллахыг "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ, "Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ, "Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ, "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК, "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ний удирдлагуудад тус тус;

4. Хөрсний усны ундаргаас үүдэлтэй халиа дошинг цэвэрлэж, цэвэрлэгээнээс гарсан цас мөсийг зөөж тээвэрлэхийг "Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ, Дүүргийн хог хаягдлын үйлчилгээний байгууллагад тус тус;

5. Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн шон, түүний хамгаалалтын бүрээс, том оврын нарс модны гэрэлтүүлгийн тоос шороо, тортогийг угааж цэвэрлэх, хууларч урагдсан хамгаалалтын бүрээсийг засаж сэргээх, гэрэлтүүлгийн шонгийн алдагдсан тагийг нөхөж тавих, эвдэрч гэмтсэн хэсгийг засах, шатсан гэрэлтүүлэгч, гэрлэн чимэглэлийг сольж, гэрэлтүүлгийн асалтыг 100 хувьд хүргэх арга хэмжээ авч ажиллахыг гэрэлтүүлгийн арчлалт хариуцсан мэргэжлийн байгууллагуудад тус тус;

6. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулсан гадна зар сурталчилгааны байгууламж, автобусны дундын зогсоолын тоос шороо, тортогийг угааж, эвдрэл гэмтлийг засварлахыг гадна зар сурталчилгааны байгууламж болон автобусны дундын зогсоолын ашиглалт, үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагуудад тус тус;

7. Золбин нохой, муур устгалын үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг устгалын мэргэжлийн байгууллагуудад тус тус;

8. Барилга байгууламжийн хашааны өнгө үзэмжийг сайжруулах, хашаан дээр наагдсан зар сурталчилгааг хуулуулж, цэвэрлүүлэх, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Нийслэлийн Газрын албанд тус тус;

9. Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлээнд албан даалгаварт заасан чиглэлүүдээр тодорхой төлөвлөгөө гаргаж, байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг нэгдсэн зохион байгууллалтад оруулан ажиллахыг албан даалгаварт нэр дурдагдсан байгууллагуудад тус тус;

10. Албан даалгаврын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд заалт бүрээр зохион байгуулж, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн орчны 50 хүртэлх метр нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлүүлэх, байгууллагын гадна фасад, цонх, хаяг, хаягийн байгууламжийг угааж, эвдэрч гэмтсэн хэсгийг засварлуулах ажлыг зохион байгуулахыг Дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус


11. Албан даалгаврын хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавьж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны холбогдох хэлтсийг тогтмол мэдээллээр хангаж ажиллахыг хяналтын төрийн бус байгууллагуудын удирдлагуудад тус тус;

12. Албан даалгаврын чиглэл тус бүрээр хяналт, шалгалт хийх нэгдсэн удирдамж гарган ажиллаж, үүргээ хэрэгжүүлээгүй, хангалтгүй ажилласан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт тус тус;

13. Албан даалгаврын биелэлтийг холбогдох заалт тус бүрээр гаргаж, 2019 оны 02 дугаар сарын 02-ны дотор "Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв" ОНӨААТҮГ-т ирүүлэхийг дүүргүүдийн Засаг дарга нар болон албан даалгаварт нэр дурдагдсан харьяа газар, агентлаг, мэргэжлийн байгууллагуудад, 2019 оны 02 дугаар сарын 03-ны дотор биелэлтийг нэгтгэж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны холбогдох чиглэлийн хэлтсүүдэд ирүүлэхийг "Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв" ОНӨААТҮГ-т тус тус;

14. Албан даалгаврын хэрэгжилтийг чиг үүргийн хүрээнд нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангаж, хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн дүн мэдээг хянаж, эцэслэн нэгтгэж ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/, Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т тус тус;

15. Албан даалгаврын хэрэгжилт, нэгдсэн дүн мэдээг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн ээлжит шуурхай зөвлөгөөнд танилцуулахыг Аудит, дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаа/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР